



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/11/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Төлбөрийн акт.....	14
4.2 Албан шаардлага	14
4.2 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail: bayankhongor@audit.gov.mn

2022.02.15 № 2/71

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D- alban bichig 2022 A4 TOOT

005070388

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	36,724,844.38	54,435,628.44
33	АВЛАГА	378,850.94	00.00
335	Бусад авлага	378,850.94	00.00
3351	Байгууллагаас авах авлага	378,850.94	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	36,345,993.44	54,435,628.44
351	Түүхий эд материал	7,197,658.48	13,373,820.48
35110	Тусгай зориулалттай материал	6,577,658.48	11,438,820.48
35130	Эм боох материал	620,000.00	1,935,000.00
354	Хангамжийн материал	29,148,334.96	41,061,807.96
35410	Бичиг хэргийн материал	1,539,830.00	1,706,730.00
35420	Аж ахуйн материал	22,278,550.00	30,633,356.00
35450	Барилгын засварын материал	1,710,000.00	1,536,950.00
35460	Хүнсний материал	701,257.46	3,755,574.46
35470	Бусад хангамжийн материал	2,918,697.50	3,429,197.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	542,670,822.92	556,887,456.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	542,670,822.92	556,887,456.60
392	Биет хөрөнгө	469,220,822.92	483,437,456.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	460,024,287.00	463,224,287.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,455,212.56	-23,182,818.84
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,166,041.22	42,206,997.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	-16,061,426.68	-15,257,017.84
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,057,830.40	39,850,429.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-27,884,996.46	-24,778,720.34
39217	Ном	1,374,300.00	1,374,300.00
393	Биет бус хөрөнгө	73,450,000.00	73,450,000.00
39301	Програм хангамж	693,000.00	693,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-693,000.00	-693,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	73,450,000.00	73,450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	579,395,667.30	611,323,085.04
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	579,395,667.30	611,323,085.04
51	Засгийн газрын хувь оролцоо	579,395,667.30	611,323,085.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	484,275,580.62	484,275,580.62
51101	Өмч: - төрийн	484,275,580.62	484,275,580.62
512	Хуримтлагдсан үр дүн	-36,276,487.53	-4,349,069.79
51210	Өмнөх үеийн үр дүн	-36,276,487.53	-36,276,487.53
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	31,927,417.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	131,396,574.21	131,396,574.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	579,395,667.30	611,323,085.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	209,777,500.00	358,187,512.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	175,915,200.00	291,281,562.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,248,500.00	10,846,162.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,248,500.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,248,500.00	5,475,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	00.00	5,371,162.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	170,666,700.00	280,435,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	170,666,700.00	280,435,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	170,666,700.00	280,435,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,923,800.00	10,646,963.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,923,800.00	10,646,963.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,938,500.00	56,258,987.18
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,938,500.00	56,258,987.18
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	200,590,360.68	325,175,094.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	200,590,360.68	325,175,094.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	200,522,560.68	308,725,834.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,734,575.46	186,627,702.57
210101	Үндсэн цалин	107,865,752.46	162,386,670.57
210102	Нэмэгдэл	11,742,000.00	6,624,372.00
210104	Урамшуулал	11,126,823.00	17,616,660.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,821,968.00	28,660,250.94
210201	Тэтгэврийн даатгал	12,615,968.00	21,900,450.74
210202	Тэтгэмжийн даатгал	1,298,400.00	1,689,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,041,860.00	1,352,000.20
210204	Ажилгүйдлийн даатгал	260,740.00	338,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,605,000.00	3,379,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,059,042.88	37,928,987.18
210301	Гэрэл, цахилгаан	1,055,590.88	1,441,055.18
210302	Түлш, халаалт	20,582,100.00	29,820,792.00
210303	Цэвэр, бохир ус	4,421,352.00	6,667,140.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,548,969.00	7,633,695.00
210401	Бичиг хэрэг	478,660.00	1,473,000.00
210402	Тээвэр, шатахуун	475,000.00	830,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	754,609.00	1,033,700.00
210404	Ном, хэвлэл	11,300.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	45,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	784,400.00	3,879,795.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	00.00	317,200.00
2105	Нормативт зардал	9,109,045.00	12,974,583.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,600.00	4,524,900.00
210502	Хоол, хүнс	9,075,445.00	8,449,683.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	20,746,650.00
210604	Урсгал засвар	00.00	20,746,650.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,411,300.00	1,635,200.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,111,300.00	1,045,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,837,660.34	12,518,765.44
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,837,660.34	12,518,765.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,800.00	16,449,260.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,800.00	10,760,963.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	10,646,963.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	67,800.00	114,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	5,688,297.43
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,688,297.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	9,187,139.32	33,012,417.62
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,084,999.88
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,084,999.88
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,084,999.88
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	9,187,139.32	31,927,417.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	160,056,500.00	347,341,350.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	131,320,800.00	280,435,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,735,700.00	66,905,950.18
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	131,320,800.00	280,435,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	131,320,800.00	280,435,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,923,800.00	10,646,963.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	4,923,800.00	10,646,963.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,811,900.00	56,258,987.18
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,811,900.00	56,258,987.18
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	153,392,729.51	347,341,350.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	153,392,729.51	347,341,350.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	153,392,729.51	330,892,089.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	103,691,047.38	186,627,702.57
210101	Үндсэн цалин	86,336,847.38	162,386,670.57
210102	Нэмэгдэл	9,270,000.00	6,624,372.00
210104	Урамшуулал	8,084,200.00	17,616,660.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,037,300.00	28,281,400.00
210201	Тэтгэврийн даатгал	9,996,900.00	21,521,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,010,100.00	1,689,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	807,900.00	1,352,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	202,200.00	338,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,020,200.00	3,379,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,360,804.13	37,758,987.18
210301	Гэрэл, цахилгаан	776,556.13	1,441,055.18
210302	Түлш, халаалт	18,295,200.00	29,650,792.00
210303	Цэвэр, бохир ус	3,289,048.00	6,667,140.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,140,468.00	9,006,000.00

Баянхонгор сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	116,559.00	957,600.00
210402	Тээвэр, шатахуун	350,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	412,809.00	1,033,700.00
210404	Ном, хэвлэл	20,300.00	732,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	240,800.00	5,182,700.00
2105	Нормативт зардал	5,599,350.00	17,018,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	4,509,900.00
210502	Хоол, хүнс	5,599,350.00	11,821,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	687,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	291,060.00	46,698,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	291,060.00	16,100,000.00
210602	Тавилга	00.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	00.00	20,598,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,411,300.00	1,635,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,111,300.00	1,045,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	861,400.00	3,866,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,954,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	861,400.00	912,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	16,449,260.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	10,760,963.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	10,646,963.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	114,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	5,688,297.43
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,688,297.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,663,770.49	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,418,940.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,418,940.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,418,940.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,418,940.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-2,418,940.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	4,244,830.49	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,244,830.49	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	484,275,580.62	131,396,574.21	-39,863,695.88	575,808,458.95
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	484,275,580.62	131,396,574.21	-39,863,695.88	575,808,458.95
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	3,478,615.73	3,478,615.73
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	484,275,580.62	131,396,574.21	-36,276,487.53	579,395,667.30
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	484,275,580.62	131,396,574.21	-36,276,487.53	579,395,667.30
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	484,275,580.62	131,396,574.21	-36,276,487.53	579,395,667.30
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	31,927,417.74	31,927,417.74
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	484,275,580.62	131,396,574.21	-4,349,069.79	611,323,085.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	343,082,500.00	331,006,089.75	12,076,410.3	96.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	343,082,500.00	331,006,089.75	12,076,410.3	96.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	342,968,500.00	330,892,089.75	12,076,410.3	96.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	192,316,000.00	186,627,702.57	5,688,297.4	97.0
210101	Үндсэн цалин	167,965,500.00	162,386,670.57	5,578,829.4	96.7
210102	Нэмэгдэл	6,715,800.00	6,624,372.00	91,428.0	98.6
210104	Урамшуулал	17,634,700.00	17,616,660.00	18,040.0	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,281,400.00	28,281,400.00	0.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	21,521,600.00	21,521,600.00	0.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,689,900.00	1,689,900.00	0.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,352,000.00	1,352,000.00	0.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	338,000.00	338,000.00	0.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,379,900.00	3,379,900.00	0.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,147,100.00	37,758,987.18	6,388,112.8	85.5
210301	Гэрэл, цахилгаан	1,441,100.00	1,441,055.18	44.8	100.0
210302	Түлш, халаалт	36,590,800.00	29,650,792.00	6,940,008.0	81.0
210303	Цэвэр, бохир ус	6,115,200.00	6,667,140.00	-551,940.0	109.0
2104	Хангамж, бараа материалын зардал	9,006,000.00	9,006,000.00	0.0	100.0
210401	Бичиг хэрэг	957,600.00	957,600.00	0.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	1,000,000.00	0.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,033,700.00	1,033,700.00	0.0	100.0
210404	Ном, хэвлэл	732,000.00	732,000.00	0.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариу	100,000.00	100,000.00	0.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,182,700.00	5,182,700.00	0.0	100.0
2105	Нормативт зардал	17,018,100.00	17,018,100.00	0.0	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,509,900.00	4,509,900.00	0.0	100.0
210502	Хоол, хүнс	11,821,200.00	11,821,200.00	0.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	687,000.00	687,000.00	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,698,100.00	46,698,100.00	0.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,100,000.00	16,100,000.00	0.0	100.0
210602	Тавилга	10,000,000.00	10,000,000.00	0.0	100.0
210604	Урсгал засвар	20,598,100.00	20,598,100.00	0.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, ху	1,635,200.00	1,635,200.00	0.0	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээн	1,045,200.00	1,045,200.00	0.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	0.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00	0.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	386,660.00	386,660.00	0.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,954,600.00	2,954,600.00	0.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	912,000.00	912,000.00	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	114,000.00	114,000.00	0.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	114,000.00	114,000.00	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	114,000.00	114,000.00	0.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	343,082,500.00	331,006,089.75	12,076,410.3	96.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	280,435,400.00	274,747,102.57	5,688,297.4	98.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	280,435,400.00	274,747,102.57	5,688,297.4	98.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	62,647,100.00	56,258,987.18	6,388,112.8	89.8
132001	Орон нутгийн төсвөөс	62,647,100.00	56,258,987.18	6,388,112.8	89.8
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17.00	17.00	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	06.00	06.00	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	0.0	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	120.00	120.00	0.0	100.0
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	120.00	120.00	0.0	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	120.00	120.00	0.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4923800.00	10,646,963.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4923800.00	10,646,963.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4923800.00	10,646,963.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4923800.00	10,646,963.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4923800.00	10,646,963.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4923800.00	10,646,963.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	131756716.00	183578744.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4923800.00	10,646,963.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

Тайлант жил хөрөнгө зарцуулахад нэгдүгээр гарын үсгийг эрхлэгч Э.Тулгаа, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Н.Уламбаяр нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор сумын 9 дүгээр цэцэрлэгийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжин хүүхэд хөгжүүлэх таатай орчинд хүүхдийн урлан бүтээх өөртөө үйлчлэх хөдөлмөрт сургана.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 304,656.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,569.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,198.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 3,414.4 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31,927.4 мянган төгрөгөөр буюу 5.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал болон үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	36,724.8	54,435.6	17,710.8
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	378.9	-	(378.9)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	36,346.0	54,435.6	18,089.6
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	542,670.8	556,887.5	14,216.6
Үндсэн хөрөнгө	602,765.5	620,799.0	18,033.6
Хуримтлагдсан элэгдэл	(60,094.6)	(63,911.6)	(3,816.9)
Нийт хөрөнгө	579,395.7	611,323.1	31,927.4
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	579,395.7	611,323.1	31,927.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	579,395.7	611,323.1	31,927.4

Бараа материалын дансны үлдэгдэл 54,435.6 мянган төгрөг болж 18,089.6 мянган төгрөгөөр өссөн нь, тусгай зориулалтын материал 4,861.2 мянга, эм боох материал 1,315.0 мянга, хүнсний материал 3054.3 мянга, бусад хангамжийн материал 510.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба урсгал төсвийн худалдан авалтаар барилгын засварын материал

дээр 20573.6 мянган төгрөгийн засварын материал худалдан авсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 620,799.0 мянган төгрөг болж 18,033.6 мянган төгрөгөөр өссөн нь урсгал төсвийн худалдан авалтаар 22,345.4 мянган төгрөгийн хөрөнгө, аймгийн БСУГ-аас 2,275.0 мянган төгрөгийг өртөг бүхий тоног төхөөрөмж, аймгийн ОНӨГ-ын 2021.12.28-ны өдрийн А/337 дугаар албан бичгээр 3200.0 мянган төгрөгийн склад шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 611323.1 мянган төгрөг болж 31,927.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 31,927.4 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 446,926.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 446,926.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 113,842.3 мянган төгрөгөөр бууруулж 333,083.7 мянган төгрөгөөр анх баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 343,082.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 280,435.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 62,647.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 280,435.4 мянга, орон нутгийн төсвөөс 56,258.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 5,688.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 331,006.1 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 5,688.3 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2020-2021 оны хичээлийн жилд нийт 18 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж, нийт 3 бүлэг, 90 хүүхэд хүмүүжиж байгаа бөгөөд 2021 оны үйл ажиллагааны зардалд 343,082.5 мянган төгрөг батлагдсан байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 7 зорилтын хүрээнд 50 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 92.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 280,435.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 124,584.7 мянган төгрөгөөр буюу 38.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, нормативд зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 570,553.3 мянган төгрөгийн 57 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхээс хуулийн 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 10,646.9 мянган төгрөгийн орлогын 1, зарлагын 16650.6 мянган төгрөгийн 2 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

- 2021 оны төсвийг анх 333,083.7 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 9,998.8 мянган төгрөг нэмж баталснаас 280,435.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 62,647.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тодотгон баталсан бөгөөд 5,688.3 мянга төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байгаа нь нийт зардлын 1.7

хувийг хэмнэсэн гэж үзэхээр байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасантай нийцэхгүй байна.

- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 48,621.8 мянган төгрөгөөр, тодотголоор 44,147.1 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 37,758.9 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 10,862.9 мянган төгрөг буюу 22.3 хувь хэмнэсэн.

- Бичиг хэргийн зардлыг 957.6 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 957.6 мянган төгрөг зарцуулсан нь дээрх тогтоолтой нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,650.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 378.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,271.1 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг өгснийг хэрэгжүүлж ажилласан бөгөөд биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021.06.10-ны өдрийн 30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15,028.4 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 2,248.6 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11,545.9 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 1,233.9 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийг хүргүүллээ.

4.1 Төлбөрийн акт

1. Тайлант хугацаанд Чандмань Баянхонгор ХК-руу 549.5 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн ч авлагаар тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү шилжүүлсэн 549.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тус цэцэрлэг нь 2021 оны жилийн эцсээр нийт 3,755.6 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй тайлагнасан бөгөөд 2022 оны 01 дүгээр сард ногдох хүнсний материалыг 2,056.4 мянган төгрөгөөр тооцон, 1,699.1 мянган төгрөгийг хүнсний материал илүү нөөцөлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү нөөцөлсөн 1699.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.2 Албан шаардлага

1. Цалингийн зардлыг тулгахад нийгмийн даатгалд 6-7 саруудад 1,146.6 мянган төгрөгөөр илүү, 12 дугаар сард 399.3 мянган төгрөг дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө", 17 дугаар зүйлийн 17.1 "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх нийгмийн даатгалын санд илүү мэдээлсэн 1,146.6 мянган төгрөгийн цалинг холбогдох ажилтнуудаас хасаж мэдээлэх, дутуу мэдээлсэн 399.3 мянган төгрөгийн цалинг нөхөн мэдээлж, цаашид алдаа зөрчлийг давтан гаргуулахгүй байх албан шаардлага өгөв.

2. Тайлант жил төсвийн хөрөнгөөр 10,000.0 мянган төгрөгийн тавилга худалдан авсан байгаа нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4 "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаар Засгийн газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 10,646.9 мянган төгрөгийн орлогын 1, зарлагын 16650.6 мянган төгрөгийн 2 гүйлгээг тус тус мэдээлээгүй байгаа Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10,646.9 мянган төгрөгийн орлого, зарлагын 3 гүйлгээг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, албан шаардлага өгөв.

4.2 Зөвлөмж

1. Цалингийн зардлаас бусад зардлын зарцуулалтыг тулгахад 1233.9 мянган төгрөгийн 4 гүйлгээг и баримтгүй гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6. "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6.5. Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS

6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” заалтуудыг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын 1233.9 мянган төгрөгийн анхан шатны баримтыг авч зөрчлийг арилган хуулийн дагуу мэдээлж, цаашид хууль, журмуудыг мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

2. Жилийн эцсийн тооллогын бүртгэл болон шаардах хуудас, жолоочийн тооцооны хуудсыг хөтлөхдөө холбогдох зааврын дагуу хөтлөөгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны “Маягт, заавар батлах тухай” 347 дугаар тушаалыг дагаж мөрдөөгүй байгаа нь Сангийн сайдын 2017 оны “Маягт, заавар батлах тухай” 347 дугаар тушаалыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Сангийн сайдын 2017 оны “Маягт, заавар батлах тухай” 347 дугаар тушаалын холбогдох заалтыг мөрдөж ажиллаж байгаад удирдлагын зүгээс хяналт тавьж ажиллах.

3. 2021 оны төсвийг анх 333,083.7 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 9,998.8 мянган төгрөг нэмж баталснаас 280,435.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 62,647.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тодотгон баталсан бөгөөд 5,688.3 мянга төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байгаа нь нийт зардлын 1.7 хувийг хэмнэсэн гэж үзэхээр байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаар Засгийн газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор сумын 9 дүгээр цэцэрлэг	8	13,329.3	0	0	2	2248.6	3	11,545.9	3	1,233.9

_____оОо_____